ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

**Говь-Алтай аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код:** ГАА-2022/80/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2022 он | Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр<br>Утас: 70483413<br>Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 70484055<br>Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Цэрэнханд<br>Утас: 99147999<br>Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10
3. Аудитын тайлан ........ 12
3.1 Ерөнхий зүйл ........ 12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12
3.4 Материаллаг байдал ........ 13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 14
3.8 Аудитын гол асуудал ........ 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 15
4. Аудитын илрүүлэлт ........ 15
4.1 Залруулсан алдаа ........ 15
4.2 Төлбөрийн акт ........ 16
4.3 Албан шаардлага ........ 16
4.4 Зөвлөмж ........ 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E –mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 14

танай ________ -ны № ________ -т

АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ДОНОЙ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг зөрчсөн, удирдлагын тушаал шийдвэргүйгээр цалин олгосон зэрэг 15.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь: Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." /тогтоосон шийдвэр/" Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" журам, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

07??? 120

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **109,525,173.74** | **101,062,335.74** |
| **33** | **АВЛАГА** | - | 16,400.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 16,400.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 109,525,173.74 | 101,045,935.74 |
| **354** | **Хангамжийн материал** | 109,525,173.74 | 101,045,935.74 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,331,275.00 | 1,354,575.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 42,680,452.74 | 35,750,052.74 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 63,436,108.00 | 63,941,308.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **514,489,124.53** | **444,706,457.00** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 514,489,124.53 | 444,706,457.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 401,979,657.93 | 356,980,340.28 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 292,059,259.99 | 292,059,259.99 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (23,375,233.54) | (32,314,992.58) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 124,670,000.00 | 85,620,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (49,792,333.17) | (47,732,833.14) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 86,085,689.00 | 99,040,689.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (32,179,912.05) | (47,638,808.28) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 11,591,700.00 | 16,905,900.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (7,079,512.30) | (8,958,874.71) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 112,509,466.60 | 87,726,116.72 |
| 39301 | Программ хангамж | 5,490,000.00 | 5,490,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (4,240,000.12) | (5,490,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 122,984,000.00 | 122,984,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (11,724,533.28) | (35,257,883.28) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **624,014,298.27** | **545,768,792.74** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **624,014,298.27** | **545,768,792.74** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 624,014,298.27 | 545,768,792.74 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 364,959,389.48 | 364,959,389.48 |
| 51101 | Өмч: - төрийн | 364,959,389.48 | 364,959,389.48 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 228,037,246.10 | 149,791,740.57 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 228,037,246.10 | 228,037,246.10 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (78,245,505.53) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 31,017,662.69 | 31,017,662.69 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **624,014,298.27** | **545,768,792.74** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **812,118,636.00** | **710,856,720.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **174,691,636.00** | **910,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 174,691,636.00 | 910,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 174,691,636.00 | 910,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 910,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **637,427,000.00** | **709,946,720.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 8,775,000.00 | 46,107,620.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 4,400,000.00 | 10,979,120.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 2,640,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,375,000.00 | 30,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 2,488,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 628,652,000.00 | 663,839,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 628,652,000.00 | 663,839,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **685,110,470.01** | **765,177,225.53** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **685,110,470.01** | **765,177,225.53** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 653,195,918.01 | 755,821,699.80 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 387,150,437.00 | 417,588,325.00 |
| 210101 | Үндсэн цалин | 272,367,460.00 | 311,780,956.00 |
| 210102 | Нэмэгдэл | 51,954,743.00 | 79,660,511.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 20,117,000.00 | 21,846,858.00 |
| 210104 | Урамшуулал | 13,828,928.00 | 4,300,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 47,587,339.00 | 53,280,417.27 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,902,359.35 | 37,523,180.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,870,865.78 | 4,174,925.54 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,096,698.62 | 3,339,940.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 656,583.10 | 749,306.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,060,832.15 | 7,493,064.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,306,975.00 | 21,404,866.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | |

| | | | |
|---|---|---|---|
| | | 1,128,263.00 | 1,877,855.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,703,911.00 | 18,305,655.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,474,801.00 | 1,221,356.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,595,119.60 | 29,108,358.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,937,200.00 | 1,099,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,224,032.00 | 17,210,946.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,483,327.00 | 1,458,812.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 64,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,787,300.00 | 1,186,000.00 |
| 210408 | Бараа материал актлалсны зардал | 5,043,260.60 | 7,968,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,000,000.00 | 9,544,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 9,544,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,518,000.00 | 9,709,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,518,000.00 | 9,709,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 109,624,680.00 | 138,693,866.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 107,619,610.00 | 137,767,970.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 402,030.00 | 128,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 232,600.00 | 150,356.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 88,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 924,000.00 | 558,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 34,440.00 | 34,440.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 61,413,367.41 | 76,492,067.53 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,145,000.00 | 1,324,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 346,500.00 | 590,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 55,921,867.41 | 74,576,867.53 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 31,914,552.00 | 9,355,525.73 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,999,600.00 | 7,977,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,999,600.00 | 7,977,600.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 23,914,952.00 | 1,377,925.73 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 23,914,952.00 | 1,377,925.73 |



ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **127,008,165.99** | **(54,320,505.53)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 24,291.89 | 23,925,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 24,291.89 | 23,925,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (24,291.89) | (23,925,000.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **126,983,874.10** | **(78,245,505.53)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 364,959,389.48 | 31,017,662.69 | 228,037,246.10 | 624,014,298.27 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **364,959,389.48** | **31,017,662.69** | **228,037,246.10** | **624,014,298.27** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | 0.00 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **364,959,389.48** | **31,017,662.69** | **228,037,246.10** | **624,014,298.27** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **364,959,389.48** | **31,017,662.69** | **228,037,246.10** | **624,014,298.27** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **364,959,389.48** | **31,017,662.69** | **228,037,246.10** | **624,014,298.27** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зөрүү | | | | |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -78,245,505.53 | -78,245,505.53 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **364,959,389.48** | **31,017,662.69** | **149,791,740.57** | **545,768,792.74** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **638,427,000.00** | **710,856,720.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,000,000.00** | **910,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,000,000.00 | 910,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,000,000.00 | 910,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 910,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **637,427,000.00** | **709,946,720.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 8,775,000.00 | 46,107,620.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 4,400,000.00 | 10,979,120.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 2,640,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,375,000.00 | 30,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 2,488,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 628,652,000.00 | 663,839,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 628,652,000.00 | 663,839,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **633,697,000.00** | **682,137,520.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **633,697,000.00** | **682,137,520.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **601,782,448.00** | **672,765,594.27** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 386,150,437.00 | 417,588,325.00 |
| 210101 | Үндсэн цалин | 271,367,460.00 | 311,780,956.00 |
| 210102 | Нэмэгдэл | 51,954,743.00 | 79,660,511.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 20,117,000.00 | 21,846,858.00 |
| 210104 | Урамшуулал | 13,828,928.00 | 4,300,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 47,587,339.00 | 53,280,417.27 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,902,359.35 | 37,523,180.83 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,870,865.78 | 4,174,925.54 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,096,698.62 | 3,339,940.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 656,583.10 | 749,306.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,060,832.15 | 7,493,064.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой** | 19,306,975.00 | 21,404,866.00 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| | **тогтмол зардал** | | |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,128,263.00 | 1,877,855.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,703,911.00 | 18,305,655.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,474,801.00 | 1,221,356.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,584,517.00 | 18,670,420.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,783,200.00 | 959,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,498,200.00 | 15,003,108.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,483,327.00 | 1,458,812.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | 97,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,499,790.00 | 1,031,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,189,000.00 | 9,764,800.00 |
| 210602 | Тавилга | - | 130,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 9,634,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,518,000.00 | 9,709,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,518,000.00 | 9,709,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 111,474,680.00 | 140,397,566.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 109,469,610.00 | 139,471,670.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 402,030.00 | 128,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 232,600.00 | 150,356.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 88,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 924,000.00 | 558,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 34,440.00 | 34,440.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,991,500.00 | 1,950,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,645,000.00 | 1,359,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 346,500.00 | 590,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **31,914,552.00** | **9,371,925.73** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,999,600.00 | 7,994,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,999,600.00 | 7,994,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 23,914,952.00 | 1,377,925.73 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 23,914,952.00 | 1,377,925.73 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **4,730,000.00** | **28,719,200.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **4,730,000.00** | **28,719,200.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4,730,000.00** | **28,719,200.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 4,730,000.00 | 28,719,200.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 4,730,000.00 | 28,719,200.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(4,730,000.00)** | **(28,719,200.00)** |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 00 | 00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 664,839,100.00 | 663,371,174.27 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 664,839,100.00 | 663,371,174.27 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 656,839,100.00 | 655,377,174.27 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 417,623,500.00 | 417,588,325.00 |
| 210101 | Үндсэн цалин | 322,944,300.00 | 311,780,956.00 |
| 210102 | Нэмэгдэл | 59,727,200.00 | 79,660,511.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 32,252,000.00 | 21,846,858.00 |
| 210104 | Урамшуулал | 2,700,000.00 | 4,300,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 53,838,800.00 | 53,280,417.27 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,197,900.00 | 37,523,180.83 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,160,200.00 | 4,174,925.54 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,328,200.00 | 3,339,940.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 832,000.00 | 749,306.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,320,500.00 | 7,493,064.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,406,200.00 | 21,404,866.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,500,000.00 | 1,877,855.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,306,200.00 | 18,305,655.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,600,000.00 | 1,221,356.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,054,000.00 | 13,053,920.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,800,000.00 | 959,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,900,000.00 | 9,279,608.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,740,000.00 | 1,458,812.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 64,000.00 | 97,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,430,000.00 | 1,138,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,085,000.00 | 20,079,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210602 | Тавилга | 5,450,000.00 | 5,444,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,635,000.00 | 9,634,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,000,000.00 | 4,994,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,000,000.00 | 4,994,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 123,871,600.00 | 123,026,446.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 122,938,800.00 | 122,100,550.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 128,100.00 | 128,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 151,000.00 | 150,356.00 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 560,000.00 | 558,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 38,700.00 | 34,440.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,960,000.00 | 1,950,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,360,000.00 | 1,359,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 600,000.00 | 590,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 8,000,000.00 | 7,994,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,000,000.00 | 7,994,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,000,000.00 | 7,994,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 664,839,100.00 | 663,371,174.27 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 663,839,100.00 | 662,461,174.27 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 663,839,100.00 | 662,461,174.27 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,000,000.00 | 910,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 910,000.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **46,107,620.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **46,107,620.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 46,107,620.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,723,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,723,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,763,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,763,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,715,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,715,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 30,906,120.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 30,906,120.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 46,107,620.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 46,107,620.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 10,979,120.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,640,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 30,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,488,500.00 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэнханд гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгаль орчин, аялал жуулчлалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, тухайн аймгийн нутаг дэвсгэрт байгаль хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчин, аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, ус цаг уур орчны шинжилгээний ажилд дэмжлэг үзүүлэх, байгаль орчин, аялал жуулчлалын сургалт сурталчилгааны ажлыг гүйцэтгэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 685.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 14.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 11.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2021 оны нийт зардал 765.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 15.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 12 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 67 хувиар буюу 3,234.0 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 101.0 сая төгрөг болж 8.5 сая төгрөгөөр буурсан нь хангамжийн материал хасагдсантай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 50.2 сая төгрөгийн материал авч, үйл ажиллагаандаа 50.7 сая төгрөгийн материалыг зарцуулж, 101.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 622.0 сая төгрөг болж 20.7 сая төгрөгөөр буурсан нь 49.5 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг шилжүүлсэнтэй холбоотой. Төсвийн хөрөнгөөр 28.7 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

Авлага дансанд эхний үлдэгдэлгүй, эцсийн үлдэгдэл 0.016 сая төгрөг байна. Энэ нь ажиллагсадтай холбоотой авлага байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 545.7 сая төгрөг болж 78.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 12 хувиар буюу 101.0 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оноос үнэ төлбөргүй авсан хөрөнгө буурсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 149.7 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 814.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 150.1 сая төгрөгөөр бууруулж, 664.8 сая төгрөгөөр баталжээ.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 664.8 сая төгрөгийн төсөв баталснаас 663.8 сая төгрөгийг улсын төсвөөс, төсөвт байгууллагын орлогоос 1.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 663.8 сая төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 0.9 сая төгрөг, урсгал үйл ажиллагаанд 663.3 сая төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 1.3 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Төсөвт байгууллагын өөрийн орлого 0.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1.4 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 0.6 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх бараа ажил үйлчилгээний зардлыг 0.8 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 10.9 сая төгрөг, ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 2.0 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнөөс 30.0 сая төгрөг, тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 2.5 сая төгрөг нийт 46.1 сая төгрөг орсноос бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 30.9, дотоод албан томилолтод 4.7 сая төгрөг, тээвэр шатахууны зардалд 5.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

**3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 2021 оны 376.8 сая төгрөгийн 55 мэдээллийг ил тод байршуулахаас 236.4 сая төгрөгийн 15 мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 0.8 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2.7 сая төгрөгийн залруулга хийж, 8.7 сая төгрөгийн албан шаардлага, 0.5 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжүүлж ажилласан байна. Өмнөх шийдвэрийн хэрэгжээгүй үлдэгдэл 5.9 сая төгрөгийн албан шаардлагын биелэлтийг 2022 оны 02 дугаар сарын 1 -ны өдрийн 58 дугаар албан тоот, нотлох баримтаар ирүүлсэн.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар бараа материалын тайлангийн тулгалт, төсвийн хэмнэлтийн горимыг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 39.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 22.6 сая төгрөгийн алдааг залруулж, 0.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 16.5 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 1 заалт зөвлөмж хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

Тайлант онд 22.6 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг нөхөж шивүүлсэн.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**4.2 Төлбөрийн акт**

Ажилтанд удирдлагын шийдвэргүйгээр 0.35 сая төгрөгийн цалин олгосон, ээлжийн амралтын биеэр эдлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн1 6 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно. /тогтоосон шийдвэр/" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

**4.3 Албан шаардлага**

Батлагдсан төсвийн зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй , 14.3 сая төгрөгийн сургалтын зардал, 1.2 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Татварын тайлангаар 0.14 сая төгрөгийн мянган төгрөгийн илүү төлөлттэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй тул албан шаардлага хүргүүллээ.

Тайлант онд 0.8 сая төгрөгийн худалдан авалтын И баримтыг дутуу шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

**4.4 Зөвлөмж**

**Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Няравын шатахууны тайлангийн сар бүрийн үлдэгдэл хасахтай гарсан, тайланг заавар журмын дагуу бэлтгээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түлш, шатах тослох материалын нярвын тайланг холбогдон гарсан заавар журамд нийцүүлэн гаргах

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | БОАЖГ | 7 | 39.6 | 1 | 22.6 | 1 | 0.4 | 4 | 16.5 | 1 | |
| | Дүн | **7** | **39.6** | **1** | **22.6** | **1** | **0.4** | **4** | **16.5** | **1** | |

аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР